

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

**АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОВХИМОЛ**

2023

АГУУЛГА

Хурлын зар	3
Хуралд оролцох товч заавар	4
Хурлын дэг	5
Хурлаар хэлэлцэх асуудал	6
Хэлэлцэх асуудал №1	7
Үйл ажиллагааны хураангуй	7
Голлох тоон үзүүлэлт	8
Ногдол ашиг хуваарилалт	9
ТУЗ-ийн ажлын тайлан	10
АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	10
Хэлэлцэх асуудал №2	11
Үндэслэл	11
ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал	11
Саналын хуудсын загвар	12
Хурлаас гарах шийдвэрийн төсөл	13

ХУРЛЫН ЗАР

АПУ ХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлын 2023 оны 03-р сарын 17-ны өдрийн 23/05 тоот тогтоолоор Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 сарын 28-ны өдрийн 14:00 цагт цахимаар зохион байгуулах болсныг мэдэгдэж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр: **2023 оны 04-р сарын 07-ны өдөр**

Хувьцаа эзэмшигч та бүхэн:

1. Компанийн www.apu.mn цахим хуудсанд хурлын бүртгэлийн өдрөөс хойш нийтлэгдэх зааврын дагуу бүртгүүлж, хуралд цахимаар оролцоно.
2. Харилцагч брокер дилерийн компани эсхүл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БиДиСек ҮЦК ХК (Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 тоот, Утас: 7555-1919 /4/, 99043165)-д ажлын өдөр, ажлын цагаар очиж, санал авах хуудсаар саналаа урьдчилж өгөх боломжтой. Санал авах хуудсаар санал авах хугацаа 2023 оны 04 сарын 27-ны өдрийн 18:00 цагт дуусна.

Хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комиссын утас, цахим хаягаар ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд холбогдож авна уу.

Нэрс	Утас	Имэйл хаяг	Цахим хуудас
1 Ч.Ариунсан <i>АПУ ХК, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга</i>			
2 Б.Мягмар, Б.Эрдэнэтуяа <i>АПУ ХК, ТУЗ-ийн ажлын алба</i>			
3 Э.Солонго <i>АПУ ХК, Хуулийн алба</i>	344336-338	agm@apu.mn	www.apu.mn
4 О.Одгэрэл <i>АПУ ХК, Байгууллагын харилцааны алба</i>			
5 Д.Баясгалан <i>АПУ ХК, Мэдээллийн технологийн алба</i>			
6 П.Жаргалсайхан <i>АПУ ХК, Техник ашиглалтын алба</i>			

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
АПУ ХК, Чингисийн өргөн чөлөө-14, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар-17040, Монгол Улс

ХУРАЛД ОРОЛЦОХ ТОВЧ ЗААВАР

Хувьцаа эзэмшигч та дараах хоёр аргын аль нэгээр хуралдаа оролцож, санал өгөх боломжтой.

Цахимаар оролцох заавар	Саналын хуудсаар оролцох заавар
<ol style="list-style-type: none">1. Хурлын бүртгэлийн өдөр буюу 2023.04.07-ны өдрөөс хойш компанийн www.ari.mn цахим хуудсанд нийтлэгдэх дэлгэрэнгүй зааврын дагуу цахимаар бүртгүүлж, бүртгэлээ баталгаажуулна.2. Хурал 2023.04.28-ны өдрийн 14:00 цагт эхлэх ба өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан зааврын дагуу хуралд цахимаар оролцож, санал хураалтын үед цахимаар саналаа өгнө.	<ol style="list-style-type: none">1. Харилцагч брокер дилерийн компани эсхүл хурлын тооллогын комисс БиДиСек ҮЦК ХК (Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 тоот, Утас: 7555-1919 /4)-тай холбогдож, 2023.04.27-ны өдрийн 18:00 цагаас өмнө санал авах хуудсаар саналаа урьдчилж өгөх боломжтой.2. Харилцагч брокер нь хувьцаа эзэмшигчийн бөглөсөн саналын хуудсыг гарын үсэг, тэмдгээр баталгаажуулан, Хурлын тооллогын комисст хүргүүлснээр хувьцаа эзэмшигчийн ирц бүртгэгдэж, санал хүргэгдэнэ.

Асууж тодруулах зүйл байвал хурал зохион байгуулах комиссын 344336-338 утас, adm@ari.mn имэйл хаягаар холбоо барина уу.

ХУРЛЫН ДЭГ

Хурал 2022 оны 04 сарын 28-ний өдрийн 14:00 цагт эхэлж, 15:30 цагт дуусна.

	Үйл ажиллагаа	Шийдвэрийн төрөл	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хурлын зохион байгуулалтыг танилцуулах		14:00-14:02	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан
2	Бүртгэлийн ажиллагааны дүнг гарган, танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	14:02-14:05	Тооллогын комисс
3	Хурлыг нээх		14:05-14:10	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
4	АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах		14:10-14:35	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
5	АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайланг танилцуулах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:35-14:45	ТУЗ-ийн хараат бус гишүүн
6	Асуулт, хариулт		14:45-14:50	
7	АПУ ХК-ийн ТУЗ-ийн цалин урамшууллын талаарх мэдээллийг танилцуулах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:50-15:00	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан
8	Асуулт, хариулт		15:00-15:05	
9	Цахимаар санал өгөх зааврыг танилцуулах		15:05-15:10	Тооллогын комисс
10	Хэлэлцэх асуудлуудаар санал хураалт явуулах		15:10-15:20	Тооллогын комисс
11	Санал хураалтын дүн гаргаж, хуралд оролцогчдод танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	15:20-15:27	Тооллогын комисс
12	Хурлыг хаах		15:27-15:30	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах.


ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1

АПУ ХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ


Цэвэр борлуулалтын орлого

тэрбум төгрөг




Үйл ажиллагааны ашиг

тэрбум төгрөг




Борлуулалтын тоо хэмжээ

сая.литр




Цэвэр ашиг

тэрбум төгрөг




Бүтээгдэхүүний нэр төрөл

SKU



Ажилчдын тоо



ГОЛЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Тоон үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Аудитлагдаагүй	Аудитлагдсан	Өөрчлөлт %
		нэгтгэсэн санхүүгийн тайлан 2022	нэгтгэсэн санхүүгийн тайлан 2021	
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ	мян.литр	158,800	170,210	7% ↓
ОРЛОГО ҮР ДҮН				
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	838,823	678,164	24% ↑
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	163,498	197,893	17% ↓
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	124,839	153,686	19% ↓
БАЛАНС				
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	352,753	251,637	40% ↑
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	490,854	365,575	34% ↑
Нийт хөрөнгө	сая.төг	843,607	617,212	37% ↑
Нийт өр төлбөр	сая.төг	210,414	112,226	87% ↑
Нийт эздийн өмч	сая.төг	633,193	504,987	25% ↑
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	843,607	617,212	37% ↑
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	112,702	181,590	38% ↓
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(86,658)	(65,594)	32% ↑
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(64,956)	(102,778)	37% ↓
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(38,912)	13,219	394% ↓
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	77,278	64,059	21% ↑
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	38,365	77,278	50% ↓
ТАТВАР ТӨЛӨЛТ				
ОАТ	сая.төг	196,919	211,313	7% ↓
НӨАТ	сая.төг	71,989	69,359	4% ↑
Бусад	сая.төг	128,588	84,338	52% ↑
Нийт татвар төлөлт	сая.төг	397,495	365,010	9% ↑
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	86,529	69,151	25% ↑

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

АПУ ХК-ийн ТУЗ-өөс 2022 оны нийлбэр дүнгээр компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд нийт 89 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болно.

Тайлант хугацаа	ТУЗ-өөс ногдол ашиг зарласан өдөр	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр	Ногдол ашиг төлөхөөр тогтоосон сүүлийн өдөр	Ногдол ашигийг ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан төлсөн өдөр
2022 оны I хагас жил	2022.08.03	45 төг	2022.08.22	2023.02.10	2022.12.30
2022 оны II хагас жил	2023.02.13	44 төг	2023.04.07	2023.12.31	-
НИЙТ		89 төг			



ТУЗ-ИЙН АЖЛЫН ТАЙЛАН

ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн дотоод дүрэм журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлж ажиллахдаа нийт 11 удаа хуралдаж, 52 тогтоол шийдвэр гаргалаа.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 3 удаа, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо тус бүр 1 удаа хуралдаж, хариуцсан чиг үүргийн хүрээнд санал, дүгнэлт, шийдвэр гаргаж ажиллав.

АПУ ХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

“АПУ групп компани 2022 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” хэмээн ТУЗ дүгнэсэн болно.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2

АПУ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН УРАМШУУЛЛЫГ ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ

ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан Компанийн засаглалын кодексийн Зургаадугаар зарчмын 6.1-д “ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцэж батална” хэмээн заасан.

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Компанийн дүрмийн 7.22.8 дугаар зүйлийг үндэслэн ТУЗ-өөс 2022 оны 05 сарын 06-ны өдрийн 22/07 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн үндсэн цалинг (татвар, хуулиар шаардсан бусад суутгалыг хасаагүй дүн) ТУЗ-ийн дарга 10 сая төгрөг, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая төгрөгөөр тогтоосон.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг дээр дурдсан тогтмол дүнгээр, сар бүр, мөнгөн хэлбэрээр олгон, гүйцэтгэлийн урамшуулал, аливаа нэмэгдэл хөлс олгохгүй байхаар шийдвэрлүүлэх санал оруулав.

САНАЛЫН ХУУДСЫН ЗАГВАР

АПУ ХК –ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн
23/05 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цагт цахимаар хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

	Хурлаас гарах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан бол санал
1	АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах				
2	АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллыг батлах				

Санал өгсөн хувьцаа эзэмшигч _____ (гарын үсэг)

Брокер (ҮЦК-аар дамжуулж санал өгсөн бол) _____ (гарын үсэг, тэмдэг)

Санал өгсөн огноо: 2023 оны ___ сар ___ өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга _____ (Б.Онон)

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Санал авах хуудсыг ашиглах санамж:

- Хувьцаа эзэмшигч нь хурлын бүртгэлийн өдөр буюу 2023 оны 04-р сарын 07-ны өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгнө.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахимаар явагдах ба хурлын үеэр санал хураалтыг цахимаар явуулна.
- Цахим хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид өөрийн харилцдаг үнэт цаасны компани эсвэл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БиДиСек ҮЦК ХК (Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот) дээр очиж хурлын материалтай танилцаад энэхүү санал авах хуудсаар 2023 оны 04 сарын 27-ны өдрийн 18:00 цаг хүртэл урьдчилан санал өгөх боломжтой.
- Саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
- Тэмдэглэгээ хийгээгүй, засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛУУДЫГ БАТЛАХ ТУХАЙ

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын шийдвэр, Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан доорх дүгнэлтийг баталсугай.
 - 1.1. АПУ групп компани 2022 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан.
2. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллыг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ц.ЭРДЭНЭБИЛЭГ

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны
04-р сарын 28-ны өдрийн ээлжит хурлын
..... тогтоолын хавсралт

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн гишүүдийн цалин, урамшуулал

№	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	Нэрс	Сарын үндсэн цалин (төгрөгөөр)
1	ТУЗ-ийн дарга	П.Батсайхан	10,000,000
2	ТУЗ-ийн ердийн гишүүн	Б.Батбаяр	6,500,000
3	ТУЗ-ийн ердийн гишүүн	Сергей Громов	6,500,000
4	ТУЗ-ийн ердийн гишүүн	Кеннет Чу	6,500,000
5	ТУЗ-ийн ердийн гишүүн	Сэн И-Ин	6,500,000
6	ТУЗ-ийн ердийн гишүүн	Д.Миеэгомбо	6,500,000
7	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Ё.Гэрэлчулуун	6,500,000
8	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Ж.Үнэнбат	6,500,000
9	ТУЗ-ийн хараат бус гишүүн	О.Одбаяр	6,500,000

Тайлбар:

- ТУЗ-ийн гишүүд нь сар бүр тогтмол цалингаар цалинжих бөгөөд цалинг мөнгөн хэлбэрээр олгоно.
- ТУЗ-ийн гишүүдэд гүйцэтгэлийн урамшуулал, аливаа нэмэгдэл хөлс олгохгүй.

APU COMPANY

Absolute. Pure. Unique.